



**МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр,
Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41, 32-09-16
И-мэйл: moh@moh.gov.mn, http://www.mohs.mn

2020.03.13 № 7/1235
танай _____-ны № _____-т

ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЭМНЭЛЭГ,
АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ГАЗРЫН ДАРГА, ЗАХИРАЛ НАРТ

Дэлхий дахинд үүсээд байгаа коронавируст халдвар (COVID-19)-ын урьдчилан сэргийлэлт, үеийн хариу арга хэмжээний хүрээнд Эрүүл мэндийн сайдын А/153 дугаар тушаал батлагдсаныг хавсралтаар хүргүүлж байна.

Тушаалын хэрэгжилтийг хангахад чиглэсэн холбогдох арга хэмжээг авч ажиллана уу.

Хавсралт 3 хуудастай.

ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖИЙН ГАЗРЫН
ДАРГА Я.БУЯНЖАРГАЛ



• 145201586



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2020 оны 03 сарын 04 өдөр


Дугаар А/153

Улаанбаатар хот

Түр заавар шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Захиргааны ерөнхий хуулийн 4.2.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.3, 8.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Коронавируст халдвар (COVID-19)-ын батлагдсан болон сэжигтэй цогцсыг оршуулахад баримтлах түр заавар"-ыг хавсралтаар тус тус баталсугай.
2. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, анхан болон лавлагаа шатлалын эмнэлгийн дарга, захирал нарт тус тус үүрэг болгосугай.
3. Уг тушаалын хэрэгжилтэд мэргэжил аргагүйн дэмжлэг үзүүлж, хяналт тавьж ажиллахыг Эмгэг судлалын үндэсний төв (Г.Уянга), Халдварт өвчин судлалын үндэсний төв (Д.Нямхүү), Зоонозын өвчин судлалын үндэсний төв (Д.Цогтбадрах)-д тус тус үүрэг болгосугай.
4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/135 дугаар тушаалын 10 дугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД  Д.САРАНГЭРЭЛ

- 141200539

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (COVID-19)-ЫН БАТЛАГДСАН БОЛОН СЭЖИГТЭЙ ЦОГЦСЫГ ОРШУУЛАХАД БАРИМТЛАХ ТҮР ЗААВАР

1. Коронавируст халдвар (COVID-19)-тай нь лабораторийн шинжилгээгээр батлагдсан, эмнэлзүй, тархвар судлалаар сэжигтэй тохиолдол гэж үзсэн тохиолдолд эмгэг судлалын шинжилгээ хийхгүй.

2. Шалтгаан тодорхойгүй уушгины цочмог үрэвсэл өвчнөөр нас барагчийн цогцост аль болох задлан шинжилгээ хийхгүй.

3. Коронавируст халдварын сэжигтэй болон онош батлагдсан өвчтөн нас барсан даруйд тухайн эрүүл мэндийн байгууллага нь чандарлах бэлтгэлийг хангах зорилгоор харьяа нийслэл, орон нутгийн онцгой комисст мэдээлнэ.

4. Онцгой комисс нь мэргэжлийн байгууллагын санал дүгнэлтийг үндэслэн чандарлах шийдвэрийг гарган, байлцах төлөөлөгчийг томилж, гүйцэтгүүлнэ.

5. Цогцсыг бэлтгэх, тээвэрлэх, хадгалах, оршуулах үйл ажиллагаанд халдварын сэргийлэлт хяналтын дараах дэглэмийг баримтална. Үүнд:

5.1. Дээрх үйл ажиллагаанд оролцох хүн бүр нүд, нүүрний хамгаалалт гутал, урт ханцуйтай, шингэн нэвтэрдэггүй халад, комбинзон, усны хамгаалалттай хормогч,-агаарын дуслыг 95% буюу түүнээс дээш шүүх үзүүлэлттэй шүүлтүүр бүхий нэг удаагийн амны хаалт, ахуйн бээлий өмсөнө.

5.2. Хууль сахиулах байгууллагын албан хаагчид хэргийн газарт ажиллах, цогцос тээвэрлэх, хадгалах, зайлшгүй шаардлагаар задлан шинжилгээ хийх, сорьц авах үед хувийн хамгаалах хэрэгслийг бүрэн өмсөнө.

5.3. Цогцсыг тээвэрлэхдээ шингэн нэвтрэхгүй эдлийг дэвсэж, 0.3%-ийн жавелионы уусмалаар норгосон даавуугаар цогцсыг битүү сроож, 2 давхар уутанд хийж, уутны бүх гадаргууг халдваргүйжүүлэн, "халдварын эрсдэлтэй" гэж тэмдэглэн цогцос хадгалах хэсэгт зөөвөрлөнө.

5.4. Цогцсыг зориулалтын чандарлах газарт оршуулах бөгөөд оршуулгыг халдвар хамгаалал, био аюулгүй ажиллагааны дэглэмийн зааврыг баримтлан тархвар судлаачийн хяналтад гүйцэтгэнэ.

5.5. Цогцос болон чандрыг улс, бүс нутаг хооронд шилжүүлэхийг хориглоно.

5.6. Орон нутагт хүн ам оршин суудаг газраас 15 км-ээс доошгүй зайтай газрыг сонгож дараах дэглэмийг мөрдөн оршуулна.

5.6.1. Цогцсыг 2 метр урт, 1 м өргөн, 1,5 метр гүн ухаж, нүхний нарийн талаас 60°-аас доошгүй налуу гаргана.

5.6.2. Нүхний ёроолд 80 см-ээс доошгүй зузаантай түлш өрж цогцсоо байрлуулж, цогцсын дээр 1 метр зузаан түлш тавьж 60-70 литр шатахуун асгаж салхин дээрээс нь галтай бамбар зайнаас шидэж гал өгнө.

5.6.3. Цогцос шатаж дуустал байнгын харуул ажиллана.

5.6.4. Шатаж дууссаны дараа халдваргүйжүүлэх бодис цацаж, шороогоор булна.

5.6.5. Нэг дор хэд хэдэн цогцсыг чандарлах шаардлага гарвал нүхийг томсгож ухна.

5.7. Цогцсыг зөөвөрлөх, оршуулах, зан үйлтэй холбоотой аливаа үйлдлийг хязгаарлаж, цогцостой харьцах хүний тоог цөөн байлгана.

5.8. Цогцсыг оршуулсны дараа эцсийн халдваргүйтгэл хийж, тэмдэглэл хөтөлж багийн гишүүд бүгд гарын үсэг зурж баталгаажуулна.

5.9. Цогцос оршуулахад оролцсон онцгой комиссоос томилогдсон багийн гишүүд өөрийгөө тусгаарлан эрүүл мэнддээ хяналт тавина.